



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/467

Мандалговь

Галт зэвсгийн тооллого явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "е", 29.1.6-ын "а", "л", Хууль зүйн сайдын 2015 оны А/220 дугаар тушаалаар батлагдсан "Галт зэвсгийн тооллого явуулах журам" –ын 2 дугаар зүйлийн 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн галт зэвсэг, түүнтэй адилтгах хэрэгслийн нэгдсэн тооллогыг 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс 12 дугаар сарын 01-ний хугацаанд зохион явуулсугай.

Хоёр. Сум бүрт "Иргэний болон харуул хамгаалалтын зориулалтаар ашиглагдаж байгаа галт зэвсэг, түүнтэй адилтгах хэрэгслийн тооллого явуулах ажлын хэсэг"-ийг байгуулж, бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэхийг сумдын Засаг дарга нарт, ажлын хэсгүүдийг удирдлага, зохион байгуулалт, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга(цагдаагийн хурандаа О.Амарсанаа), Татварын хэлтсийн дарга(М.Туяацэцэг) нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Галт зэвсгийн тооллого явуулах ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд сурталчилж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс(М.Цогзолмаа)-т, Иргэний болон харуул хамгаалалтын чиглэлээр ашиглагдаж байгаа галт зэвсэг, түүнтэй адилтгах хэрэгслийг улсын тооллогод бүрэн хамруулахыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

488010449